



103

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Сайд нарын Зөвлөлийн

ТОГТООЛ

1964 оны II дүгээр
сарын 5-н өдөр

Дугаар 488

Улаанбаатар
хот

Барилгын техникийн баримт бич-
гийн архив байгуулах тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын архитектурын газарт орон тоонд нь багтаан барилгын техникийн баримт бичгийн архив байгуулахыг Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа /н. ДУВСАНЧОЙМБОЛ/-д зөвшөөрсүгэй.

2. Барилгын техникийн баримт бичгийн архивт: Улаанбаатар хотын дотор баригдсан нийгэм ахуйн барилга байгууламж, тохижуулалт, ус түгээгүүр, ариутгах татуурга, дулаан, дахилгаан, зам гүүр, талбай, радио, телефоны шугам сүлжээ, топогеодезийн зураг, хөрсний ус, газар хөдлөлт, газар зүйн хайгуул зэрэг инженер хайгуулын ажлын материалыг гүйцэтгэлийн нь актуудын хамт хадгалуулж байсугай.

3. Хотын архитектурын газрын барилгын техникийн баримт бичгийн архивт 1955 оноос хойш Улаанбаатар хотын дотор баригдсан нийгэм ахуйн барилга байгууламж, хайгуулын ажлын материал I хувийг энэ онд, цашид баригдах мөн барилга байгууламж, хайгуулын ажлын зураг тэсвийг цаг тухайд нь шилжүүлэн өгч байхыг холбогдох яам, газруудын сайд, дарга нарт даалгасугай.

Б Н М А Улсын Сайд нарын
Зөвлөлийн I-р орлогч дарга

МОЛОМЖАМЦ

Б Н М А Улсын Сайд нарын
Зөвлөлийн Хэрэг эрхлэх
газрын дарга

БАДАРЧ

Хуулбар үнэн: Тогтоол ангийн



Б.А.Дорж

ДАГВАДОРЖ